

“ӨНДӨРХААН” ХК

2025 оны 4 сарын 25-ны өдөр

Дугаар 25/03

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Энгийн хувьцааны
тоог нэмэгдүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.15 дахь заалт, 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

- Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 1,721,670 (нэг сая долоон зуун хорин нэгэн мянга зургаан зуун далан) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нийт 1,833,549 (нэг сая найман зуун гучин гурван мянга таван зуун дөчин есөн) ширхэг байхаар тогтоосугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах, компанийн зарласан энгийн хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах, холбогдох баримт бичигт компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирлын түр орлон гүйцэтгэгч (Ц.Тайшир)-д олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

“ӨНДӨРХААН” ХК

2025 оны 4 сарын 25-ны өдөр

Дугаар 25/04

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Өрийг хувьцаагаар солих,
хаалттай хүрээнд энгийн
хувьцаа нэмж гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.15 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

- Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 1,721,670 (нэг сая долоон зуун хорин нэгэн мянга зургаан зуун далан) ширхэг энгийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон ӨндөрХаан ХК нарын хооронд байгуулсан холбогдох гэрээний заалтын дагуу 25,009,999,987 (хорин таван тэрбум есөн сая есөн зуун ерэн есөн мянга есөн зуун наян долоон) хүртэлх төгрөгийн өглөгийг энгийн хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэж, компанийн өрийг энгийн хувьцаанд хөрвүүлэх төслийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирлын түр орлон гүйцэтгэгч (Ц.Тайшир)-д олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

Өндөрхаан ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн
25/09 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
тогтоолын Хавсралт I



ӨНДӨРХААН ХК-ИЙН ӨРИЙГ ЭНГИЙН ХУВЬЦААНД ХӨРВҮҮЛЭХ ТӨСӨЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү компанийн өрийг энгийн хувьцаанд хөрвүүлэх төсөл /цаашид “Төсөл” гэх/-ийн зорилго нь “ӨндөрХаан” ХК /цаашид “Компани” гэх/-ийн өрийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “Санхүүгийн Зохицуулах Хороо” /цаашид “Хороо” гэх/-ны Үнэт цаасны бүртгэлийн журам, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК /цаашид “Бирж” гэх/-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад холбогдох журамд заасны дагуу Компанийн хувьцаанд хөрвүүлэх, түүнтэй холбогдон хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах, өрийг хувьцаагаар солихтой холбогдон үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Оролцогч талуудын мэдээлэл:
 - Санхүүжилт хүлээн авагч: “ӨндөрХаан” ХК;
Санхүүжилт хүлээн авагчийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р дугаар хороо, Сентрал Тауэр, 17 давхар
Санхүүжилт хүлээн авагчийн регистрийн дугаар: 2035987
 - Санхүүжилт олгогч: “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК
Санхүүжилт олгогчийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р дугаар хороо, Ард санхүүгийн нэгдлийн 2 давхар
Санхүүжилт олгогчийн регистрийн дугаар: 2001861
- 1.3. Өрийг хувьцаагаар солих үндэслэл нь “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь “ӨндөрХаан” ХК-ийг хөрөнгөжүүлэх зорилгоор нийт 25,009,999,987 хүртэлх төгрөг /цаашид “Өр” гэх/-ийн санхүүжилтийг дараах байдлаар олгосон бөгөөд Компани тус Өрийг Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу нэмж хувьцаа гаргах замаар өрийг хувьцаагаар солихоор тус тус шийдвэрлэсэн.
 - 1.3.1. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 07 сарын 08-ны өдрийн 23/19-1 дугаартай тогтоолын дагуу “ӨндөрХаан” ХК-ийг 10,010,000,000 хүртэлх төгрөгөөр хөрөнгөжүүлэх зорилгоор олгосон;
 - 1.3.2. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 07 сарын 08-ны өдрийн 23/19-2 дугаартай тогтоолын дагуу “ӨндөрХаан” ХК-ийг 15,000,000,000 хүртэлх төгрөгөөр хөрөнгөжүүлэх зорилгоор олгосон.

ХОЁР. ӨРИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ, ГАРГАХ ХУВЬЦААНЫ ТОО ХЭМЖЭЭ

- 2.1. ӨндөрХаан ХК нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д нийт 25,009,999,987 хүртэлх өглөгтэй бөгөөд тус өглөгийг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Компани нарын хооронд байгуулсан

Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ болон Өрийг хувьцаагаар солих гэрээний холбогдох заалтын дагуу Өрийг хувьцаанд хөрвүүлнэ.

- 2.2.Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 14,526.59 төгрөгийн ханшаар үнэлэж 1,721,670 ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гарган энэхүү Төслийн 2.1 дэх хэсэгт заасан Өрийг хувьцаагаар солино.

ГУРАВ. ГАРГАХ ХУВЬЦААНЫ ҮНЭ

- 3.1.Биржийн 03/208 дугаартай Компанийн үнэт цаасны 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс өмнөх сүүлийн 52 долоо хоногийн жигнэсэн дундаж ханш 14,526.59 төгрөг байсан ба уг ханшид үндэслэн өрийг хувьцаанд хөрвүүлэх нэгж хувьцааны ханшийг 14,526.59 төгрөг байхаар тогтоосон.

ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ

- 4.1.Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Компанийн Дүрмийн 5.5 дахь хэсэгт заасны дагуу Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 4.2.Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нь 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 09:00 цагаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Централ Тауэр, 17 давхарт болох бөгөөд тус хурлаар Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 4.3.Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр гарсан тохиолдолд хурлын шийдвэрийг үндэслэн Хорооноос зөвшөөрөл авах, компанийн санхүүгийн тайлан тэнцэлд холбогдох бичилтүүдийг хийх, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, улсын бүртгэлд бүртгүүлэх болон холбогдох бусад шаардлагатай ажлыг тус тус хийж гүйцэтгэнэ.

ТАВ. ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХТОЙ ХОЛБОГДОН ҮҮСЭХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

- 5.1.Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.8 дахь заалт, 62.1.15 дахь заалтад заасны дагуу Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс саналыг оруулан, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн, уг асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 5.2.Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг хаалттай хүрээнд гаргах шийдвэр гарсантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 53.1.2 дахь заалт, 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалт болон 87.1.2 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигч нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүснэ.

5.3. Компанийн өрийг хувьцаагаар солих ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирал томилж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах ба дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

5.3.1. Компанийн өрийг хувьцаагаар солих төслийг Компанийн тухай хууль, компанийн дүрмийн холбогдох заалтад нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэх;

5.3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн Компанийн өрийг хувьцаагаар солих гэрээний төсөл боловсруулан, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, удирдлагуудад танилцуулах, холбогдох мэдээллээр ханган ажиллах;

5.3.3. Компанийн нэмж гаргасан хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах;

5.3.4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт орохтой холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөл авах материалыг бүрдүүлэн Хороонд хүсэлт гаргах;

5.3.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрлийг үндэслэн компанийн дүрмийн өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлэх;

5.3.6. Шаардлагатай бусад.

5.4. Компанийн өрийг хувьцаагаар сольсны дараа талуудын хооронд үлдэх өр төлбөрийн асуудлыг энэхүү баримт бичгээр зохицуулахгүй болно.

5.5. Компанийн өрийг хувьцаагаар солих төслийг хэрэгжүүлснээр компанийн дүрэмд дараах өөрчлөлт орно.

<p>4.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах бөгөөд компани нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 111,879 ширхэг энгийн зарласан хувьцаатай байна.</p>	<p>4.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах бөгөөд компани нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,833,549 ширхэг энгийн зарласан хувьцаатай байна.</p>
<p>4.3. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн гаргасан хувьцааны нэрлэсэн үнэ 100 (нэг зуун) төгрөг байх бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо 111,879 ширхэг байна.</p>	<p>4.3. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн гаргасан хувьцааны нэрлэсэн үнэ 100 (нэг зуун) төгрөг байх бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо 1,833,549 ширхэг байна.</p>